

ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

Д.ӨҮЛЭН-ҮЖИН*

1996 оны 4 дүгээр сард Шанхай хотноо ОХУ, БНХАУ, Казахстан, Кыргызстан, Тажикстан зэрэг таван улсын төрийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалт болсон юм. Үүний үр дүнд “Шанхайн тав” хэмээх олон улсын засгийн газар хоорондын байгууллага үүсч Төв Азийн аюулгүй байдлын асуудлаар үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Улмаар уг байгууллагын үйл ажиллагаа улам бүр өргөжин “Шанхайн форум” гэж нэрлэгдэх болсон байна.

2001 оны 7 дугаар сард Душанбе хотноо болсон уулзалтаар Узбекистан улсыг гишүүнээр элсүүлжээ. Уг ондоо гишүүн орнууд хамтран Тунхаглал гаргаж уг байгууллагаа “Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ) хэмээн нэрлэв. Тунхаглалд зааснаар байгууллагын зорилго нь гишүүн орнуудын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, сайн хөршийн харилцааг бэхжүүлэх, тэдгээрийн хоорондын эдийн засаг, улс төр, худалдаа, зам тээвэр, соёл боловсрол, шинжлэх ухаан, техник технологи болон бусад салбарын хамтын ажиллагааг дэмжих, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах болон аливаа салан тусгаарлах, алан хядах үйл ажиллагааны эсрэг тууштай тэмцэхэд оршино” гэжээ.

“ШХАБ” нь нээлттэй байгууллага бөгөөд хүссэн улс орон бүр нэгдэн орох эрхтэй аж. Зарим улс орнууд тус байгууллагыг Америкийн дангаар ноёрхох ноёрхол болон НАТО-гийн Төв Азийн бүс нутагт өргөжиж буйг хязгаарлахын тулд Хятад улсын санаачлагаар байгуулагдсан байгууллага гэж үздэг. Харин ШХАБ үүнийг эрс эсэргүүцэн “Манай байгууллага нь цэрэг зэвсгийн ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд Төв Азийн НАТО биш” хэмээн удаа дараа мэдэгдэж байсан билээ.

Өнгөрсөн дөрөвдүгээр сард ШХАБ уулзалтандаа Ираныг урихад АНУ эрс эсэргүүцэн АНУ-ын Батлан Хамгаалах Яамны сайд Дональд Рамсфельд “Терроризмын эсрэг тэмцэнэ гэсэн уриатай атлаа террорист бүлгүүдэд тусламж үзүүлдэг төдийгүй цөмийн зэвсгийн асуудалтай байгаа ийм улсыг гишүүнээ болгохоор урьж байгаа явдлыг ойлгохгүй байна” хэмээжээ. Барууны орнууд уг байгууллагыг цэргийн томоохон хүчин байж магадгүй хэмээн сэжиглэж үүгээр дамжуулан Азийн нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой байж магадгүй гэж үзэж байгаа төдийгүй Канадын өдөр тутмын “Canada West News” хэмээх сонинд ШХАБ-ыг “Тэсрэх бөмбөгтэй ОПЕК” хэмээн нэрлэжээ.

Өнгөрсөн жилийн уулзалтын үеэр Хятад улс Пакистаныг урих санал тавихтай зэрэгцэн ОХУ Энэтхэгийг ажиглагчаар урих санал тавих нь зүйтэй хэмээн үзжээ.

АНУ болон Европын Холбоо Ираныг ШХАБ-д элсэн орвол зарим нэг талаараа ашигтай байж болох юм гэсэн дүгнэлт хийж байна. Энэ нь Иран ШХАБ-ын гишүүн орон болбол тус байгууллагын үйл ажиллагаанд оролцох болно. Ингэснээрээ Хятад болон Орос улс Ираны цөмийн хөтөлбөрт хориг тавихад нэмэр болж магад хэмээн үзэж байна. Тус улсыг гишүүнээ болгох нь дээрх хоёр оронд багагүй ашигтай, өөрөөр хэлбэл олон улсад БНХАУ болон ОХУ-ын байр суурийг бататгахад дөхөм үзүүлнэ хэмээн ажиглагчид үзэж байна.

Манай улсын тухайд анх 2004 онд Ташкентэд болсон уулзалтанд ажиглагчаар оролцсон. 2005 оны долдугаар сарын 5-нд ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн хурал Казахстан улсын нийслэл Астана хотод болж, түүнд гишүүн орнуудын төрийн тэргүүн Н.Назарбаев, Ху

* Д.Өүлэн-Үжин-ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний туслах ажилтан.

Жиньтао, К.Бакиев, В.Путин, Э.Рахмонов, И.Каримов нар оролцжээ. Үүний зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ажиглагчаар, Энэтхэгийн Гадаад хэргийн сайд Натвар Сингх, Пакистаны Ерөнхий сайд Шаукат Азиз, Ираны Тэргүүн дэд ерөнхийлөгч Моххамед Реза Арефа нар зочноор оролцсон байна.

Энэ удаагийн уулзалтанд Иран, Пакистан, Энэтхэг улсад ажиглагчийн статус олгосон байна.

ШХАБ-ын гишүүн орнууд хүмүүнлэг, соёл, боловсролын салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, энэ асуудлыг зохицуулах хууль эрхийн баримт бичиг боловсруулах асуудлыг нэлээд чухалчилж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ШХАБ-ын төрийн тэргүүн нарын уулзалтанд оролцож, Монгол Улсын өнөөгийн байдал ШХАБ-ын талаар баримталж буй манай байр суурийг илэрхийлсэн байна. Тэрээр “Монгол Улс ШХАБ-ыг бүс нутагт хамтаар хөгжин дэвших боломжийг хангах, итгэлцэл, найрамдал, сайн хөршийн харилцаа, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн, эрчимтэй хөгжиж буй байгууллага хэмээгээд ШХАБ нь зохион байгуулагдах үе шатаа дуусгаж олон талт хамтын ажиллагааны шинэ үе шатанд орж, өдгөө олон салбарт практик хамтын ажиллагааг тогтоох тодорхой зорилтуудыг амжилттай шийдвэрлэж байна.

ШХАБ-ын хүрээнд бизнесийн зөвлөл болон хөгжлийн сан байгуулах нь гишүүн орнуудын хамтын ажиллагааг өргөтгөхөд нэмэлт түлхэц болно гэж бид үзэж байна. Мөн ШХАБ-ын эдийн засгийн зорилтууд нь бүс нутгийн улс орнуудын хөгжилд бодитой дэмжлэг болж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засгийн хоцрогдлыг даван туулахад хувь нэмрээ оруулна гэж бид үзэж байна. Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх нь ШХАБ-ын гол зорилтыг хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл терроризм, экстремизм, сепаратизмыг арилгах үндсэн хүчин зүйл болох юм.

Монгол Улс ШХАБ-тай юуны өмнө худалдаа, эдийн засгийн харилцаа холбоогоо хөгжүүлэх, транзит тээврийг оролцуулан бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн

хамтын төслүүд хэрэгжүүлэхийг сонирхож байна.

Худалдаа, хөрөнгө оруулалт, тээврийн нэгдсэн сүлжээ хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой төслүүдэд оролцох боломжтой болоход бид онцгой ач холбогдол өгч байна. Тус байгууллагын ажиглагч улсуудад тийм төсөлд оролцох боломжийг нэмэгдүүлбэл бид баяртай байх болно.

ШХАБ-ын орон зайд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлэх нь жижиг улсуудад зах зээл нээх, харилцан ашигтай нөхцлөөр тэднийг бүс нутгийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд татан оролцуулах боломжийг нээж, эдгээр улсуудын хөгжилд түлхэц болох билээ” хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгч онцлон тэмдэглэжээ.

Уг хурлын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНХАУ-ын дарга Ху Жинтао, Казахстан улсын Ерөнхийлөгч Н.Назарбаев нартай уулзаж, хоёр талын харилцаа хамтын ажиллагааны сүүлийн жилүүдийн хөгжил дэвшил болон цаашдын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон байна. Мөн Кыргызстан, Тажикстан, Узбекистан, Иран, Пакистаны төлөөлөгчдийн тэргүүн нартай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар тус тус санал солилцжээ.

Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын цаашид явуулах бодлого үйл ажиллагааг дэлхий нийтээрээ анхааран харж байгаа бөгөөд манай улсын сонирхлыг ч мөн адил татаж байгаа юм. ШХАБ-ын гишүүн орнуудтай сайн хөршийн холбоог бэхжүүлэх, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн салбарт хамтран ажиллах нь манай улсын гадаад бодлогын хувьд чухал алхам болно гэж үзэж байна.

Ишлэл, зүүлт:

1. Л.Лхагвасүрэн. Монголын дипломат бодлогын шинэ сонголт: Шанхайн хамтын ажиллагааны байгууллагатай холбон авч үзэх нь. “Олон улс судлал” сэтгүүл. 2005, №4
2. “Өдрийн сонин” 2005 №270.
3. www.mongolian-foreign-policy.net
4. www.canwest.com